



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 16 өдөр

Дугаар А/204

Сүхбаатар сум

### Хөтөлбөр хэрэгжүүлэх, аян зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.9, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.12, Монгол Улсын Их Хурлын 2016 оны "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" 51 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.5 дахь зорилт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 118 дугаар тогтоолоор батлагдсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийн 2.4 дэх зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилго бүхий "Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон" аяныг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 01-нийг хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд зохисн байгуулсугай.

2. "Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон" аяны удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, аяны хүрээнд зохион байгуулагдах хяналт, шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. "Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон" аяныг болон шаггалтыг удирдамжийн дагуу зохион байгуулж, дүнг нэгтгэн танилцуулж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ө.Сувдаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш. ОРГИЛ